

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.БЯМБАДУЛАМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1.1.1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Шаардлагагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжилтийг ханган ажиллалаа. Системийн хэмжээнд шинэ программ /Sicos/ нэвтрүүлсэнтэй холбоотойгоор гарсан зөвлөмж, чиглэл, заавар, журмыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна.	100%
1.1.3.	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд	Шаардлагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо	2023 онд 101 ажил олгогч, 302 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав.	Ажил олгогчийн тоог 93, даатгуулагчийн тоог 337 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Аймгийн Татварын газарт бүртгэлтэй 2090 аж ахуйн нэгж байгууллагаас 1649 аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлагнасан байна. Үүнээс 2024 онд шинээр 146 ажил олгогч, 253 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд шимтгэл төлөгчөөр хамруулж аж ахуйн нэгж байгууллагыг шинээр хамруулах тооны төлөвлөгөөг 157 хувиар биелүүлж ажиллалаа.	100%

	хүргүүлэх.						
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, ер, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах							
2.1.15.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын шинэ систем Sicos-д ажил олгогчийн болон даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэт оруулан бүртгэж, ажил олгогчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хамт файлаар хавсарган мэдээллийн санд бүртгэж байна. 2024 оны 12 сарын 09-ний байдлаар нийт 146 аж ахуй нэгжийн 253 албан журмын даатгуулагч шинээр хамруулж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	100%
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх							
3.1.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих;		Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан.	Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна.	https://huvsgul.ndaatgal.mn/ вэб сайтад “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, дөрөвдүгээр хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг мэдээллийн самбарт байршуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллүүдээ shilen.gov.mn вэб сайтад 5 төрлийн 87 үзүүлэлтээр байршуулан ажиллаж байна. Үүнд: Хууль эрх зүй, даатгалын цахим үйлчилгээ, НД-ын үйлчилгээний төрөл, байгууллагын санхүүгийн статистик мэдээ, цаг үеийн мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны ил тод	85%

			өдрийн дотор хургуулна.			байдал, хүний нөөцийн ил тод байдал, байгууллагын төсвийн орлого, зарлагын шилэн дансны мэдээллийг харах боломжтой. https://shilen.gov.mn/index -д нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 88,5%-тай үнэлэгдсэн байна. Мөн shilen.gov.mn-д байршуулах нээлттэй мэдээллийг жилийн эцсийн байдлаар 100 хувь бүрэн байршуулж, хянасан төлөвтэй байна.	
Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах							
3.2.1.	Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.	Шаардлагагүй	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана.	Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан.	Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнд Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын хүүхдийн цэцэрлэгийн туслах багш Намжийн Наранчимэгийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн өргөдлийн дагуу Нийгмийн даатгалын газрын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 17-1348/132 дугаартай удирдамжаар Баянзүрх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2000-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж 2000 оны 8, 9 сар, 2003 оны 10 сар, 2004.10 сараас 2005.10 сарын төлөгдөөгүй хугацааны цалингийн санд ноогдуулсан шимтгэл, алдангийн нийт 163879 төгрөгийн акт тавьж, холбогдох байгууллагаар актын барагдуулалтыг хугацаанд нь хийлгэж ажиллалаа.	100%
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах							
	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай		Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол,	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан Засгийн газрын тогтоол 16, ХНХЯ-ны	100%

4.1.1.	<p>холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.</p>		<p>зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна</p>	<p>хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.</p>	<p>сайдын тушаал 15, НДҮЗ-ийн тогтоол 9, НДЕГ-ын даргын тушаал 18, журам 15, зөвлөмж 6, дүрэм 2, заавар 1, аргачлал 2 нийт 84 албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.</p>	
4.1.2.	<p>ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.</p>		<p>Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.</p>	<p>Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.</p>	<p>Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.</p>	<p>Ажил олгогчийн шинэ системээр тайлан илгээх, ажилтан бүртгэхтэй холбоотой программын алдааг шийдвэрлүүлэх хүсэлт 12, НД-ын шимтгэл нөхөн төлүүлэхтэй холбоотой өргөдөл 1, даатгуулагчийн регистер солиулах хүсэлт 10, ажил олгогчийн мэдээлэл шинэчлүүлэх хүсэлт 15 нийт 38 өргөдөл хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 36, шийдвэрлэлт 94,7%-тай байна.</p>	94,7%
4.1.5.	<p>Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх</p>		<p>Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг</p>	<p>Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.</p>	<p>Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээг нэвтрүүлсэн</p>	<p>Газрын дотоод ажлыг сайжруулах ажлын хүрээнд иргэд даатгуулагчдад 2024 онд мөрдөж байгаа НД-ын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаарх мэдээ мэдээлэл, тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох хувь хэмжээ, сайн дурын даатгалын төрөл,</p>	90%

			хэрэгжүүлсэн байна.		талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	хувь хэмжээ, шимтгэл төлөх дүн гэх мэт мэдээллийг шинэчлэн мэдээллийн самбар 2, стэнд самбар 2 шинээр хийлгэж, 1 давхрын хөтөч самбарын мэдээлэл, газрын ерөөний хаягийн мэдээллийг шинэ бүтцийн дагуу шинэчиллээ. НДЕГ-аас аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад CallPro үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотой 2024.05.08-нд дуудлагын 6 IP утсанд шинээр тохиргоо хийж, дуудлага хариуцсан байцаагч нарт суурилуулж, дуудлага хүлээн авсан, алдсан талаарх мэдээллийг долоо хоног бүрийн даваа гарагийн сонголоор дэлгэрэнгүй танилцуулж хэвшсэн.		
4.1.7.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх		Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	Прокурорын газрын зөрчлийн ахлах прокурор С.Батсүх, зөрчлийн прокурор н.Батзолбоо нар 2024 оны 04-р сарын 05-ны өдөр "Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих" сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар нийт сумдын байцаагч нарыг цахимаар хамрууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Соёмбо танхимд Авлигатай тэмцэх газрын комиссар н.Амартүвшин Авлигын хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалтанд газрын эрх бүхий албан тушаалтнууд хамрагдаж авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-ны цахим сургалтад газрын албан хаагчид бүрэн хамрагдлаа.	Хагас жилийн байдлаар 100%	
Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах								
4.2.1.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;		Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх удаагийн	-Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон	Албан хаагчдын мэдлэг ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахимаар болон танхимаар сургалт зохион байгууллаа. Үүнд: НДЕГ-ын шинэ систем (Sicos)-ийн заавар сургалтыг цахимаар 8	Хагас жилийн байдлаар	

			сургалтын тоо, хамруулсан хүний тоо	сургалтад албан хаагчийг хамруулсан.	цахим сургалт зохион байгуулна. -Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.	удаа, НДГазраас сумдын байцаагч нарт цахим сургалтыг 6 удаа, аймгийн ЗДТГ, Авлигатай тэмцэх газар, Аймгийн Прокурорын газраас 4 удаагийн хууль эрх зүйн сургалтад хамрагдсан. Сумдын байцаагч нарыг НД-ын шинэ программд дадлагажуулах танхимын сургалтыг 2 удаа нийт 44 байцаагчид хийж, дадлагажуулах сургалтын үр дүнд бүх сумдын байцаагч нар хариуцсан сумын даатгуулагчдын сайн дурын даатгалын гэрээг сум хариуцсан байцаагч нарын Sicos эрхээр орж байгуулан нийт 23 сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч 381 иргэн, ХБХА эх/эцэг-ийн 63 иргэн, 0-3 насны хүүхэдтэй 750 эхийн, малчнаар 3847 нийт 5041 сайн дурын даатгуулагчийн гэрээг байгуулж ажиллалаа.	100%																				
						<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Зохион байгуулсан газар хэлтэс</th> <th>Сурга лтын тоо</th> <th>Байцаагчийн тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>НДЕГазар</td> <td>8</td> <td>144</td> </tr> <tr> <td>2</td> <td>НДГ</td> <td>7</td> <td>104</td> </tr> <tr> <td>3</td> <td>Аймаг болон бусад байгууллага</td> <td>5</td> <td>41</td> </tr> <tr> <td></td> <td>Нийт</td> <td>20</td> <td>289</td> </tr> </tbody> </table>	№	Зохион байгуулсан газар хэлтэс	Сурга лтын тоо	Байцаагчийн тоо	1	НДЕГазар	8	144	2	НДГ	7	104	3	Аймаг болон бусад байгууллага	5	41		Нийт	20	289	
№	Зохион байгуулсан газар хэлтэс	Сурга лтын тоо	Байцаагчийн тоо																								
1	НДЕГазар	8	144																								
2	НДГ	7	104																								
3	Аймаг болон бусад байгууллага	5	41																								
	Нийт	20	289																								
4.2.2.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;		Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн удаагийн сургалтад иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	Албан байгууллага, иргэд даатгуулагчдад 2024 онд хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт, ач холбогдол, мөн НД-ын системийн хэмжээнд хийгдэж байгаа программын шинэчлэлийг ажил олгогчдод танилцуулах сургалтыг НДГазрын 39 байцаагч нар цахимаар 28 удаа, танхимаар 94 удаа зохион байгуулснаар нийт 3155 иргэд даатгуулагч, ажил олгогч нар хамрагдсан байна. Мөн явуулын үйлчилгээ, өдөрлөг арга хэмжээг зах, ХҮТөв, ЕБСургуулийн төгсөх ангийн сурагчдад, 24 сумын 129 багийн 8430 малчид, даатгуулагчдад 92 удаагийн	Хагас жилийн байдлаа р 100%																				

						иргэд нийтийн хурлаар дамжуулан НД-ын хууль тогтоомж, үйлчилгээг хүргэж ажиллалаа. Үүнд: 2024.04.23-нд “Хөвсгөл Органик” бизнес эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн, 2024.05.01-нд “Хуульчийн Про-Боно өдөр-2024” нээлттэй өдөрлөг, 2024.05.09-нд “Төрийн байгууллагын бүтээлч үйл ажиллагаа” зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаж НДГазраас тус арга хэмжээнд оролцож 1550 иргэнд НД-ын үйлчилгээг хүргэж ажилласан байна.																														
						<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2"></th> <th colspan="3">Сургалт</th> <th colspan="2">А/хэмжээ</th> </tr> <tr> <th>Сургалт тоо</th> <th>АО тоо</th> <th>Даатгуулагч тоо</th> <th>А/Хэм тоо</th> <th>Иргэд тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хэлтэс</td> <td>11</td> <td></td> <td>392</td> <td>3</td> <td>1550</td> </tr> <tr> <td>Сум</td> <td>108</td> <td>305</td> <td>2713</td> <td>92</td> <td>6680</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>119</td> <td>475</td> <td>1705</td> <td>95</td> <td>8230</td> </tr> </tbody> </table>		Сургалт			А/хэмжээ		Сургалт тоо	АО тоо	Даатгуулагч тоо	А/Хэм тоо	Иргэд тоо	Хэлтэс	11		392	3	1550	Сум	108	305	2713	92	6680	Нийт	119	475	1705	95	8230	
	Сургалт			А/хэмжээ																																
	Сургалт тоо	АО тоо	Даатгуулагч тоо	А/Хэм тоо	Иргэд тоо																															
Хэлтэс	11		392	3	1550																															
Сум	108	305	2713	92	6680																															
Нийт	119	475	1705	95	8230																															
4.2.3.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;		Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл,	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн тоо, мэдээллийн төрөл.....	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай	НДГазрын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ, мэдээллийг Хөвсгөл аймгийн НДГ page хуудсанд 46 удаа байршуулан 468 like, 92 comment, 338 share хийсэн хандалттайгаар иргэд даатгуулагчдад сошиалаар хүргэж ажиллалаа. Мөн орон нутгийн олон дагагчтай хувийн сайт болох ANZAAR сайттай хамтран мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж ажиллаж байна. НДЕГазраас хийсэн шторк, постер, Live, Video мэдээллийг хэлтсийн page хуудсаар болон байцаагч мэргэжилтнүүдийн facebook хуудсаар 338 удаа share хийлгэсэнээр 34200 иргэний хандалт авсан байна. Мөн 21 сумын байцаагч нар НДЕГ-ын бэлтгэн нийтэлсэн болон аймгийн НДГазрын нийтэлсэн постер, цаг үеийн мэдээ мэдээллийг сумын ЗДТГ-ын фэйж хуудас, сумдын зарын нэгдсэн групп,	Хагас жилийн байдлаар 70%																													

			<p>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл</p>		<p>хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>багийн иргэдийн нэгдсэн группүүдэд түгээж ажилласан байна. Өмнөх 6100 дагагчтай “Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс” фэйсбүүк пэйж хуудас нь админы нууц үгийг мэдэхгүй байгаагаас шинэ админ нэмэх, пэйж хуудасны нэрийг өөрчлөх боломжгүй болсон тул цаашид ашиглахгүй байх шийдвэр удирдлагын түвшинд гаргаж шинээр “Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар” пэйж хуудсыг нээн ажиллуулж 931 дагагчтай болсон байна. НД-ын тухай хууль тогтоомж, үйлчилгээний талаар мэдээ мэдээллийг тогтмол оруулж, ААН байгууллага, иргэд даатгуулагчдад хийсэн сургалт, сурталчилгааны мэдээллийг тухай бүр оруулж подкаст хэлбэрээр 3 удаа, Reels 5 удаа хийж нийт хандалтын тоо 2463 байна</p>	
--	--	--	---	--	---	---	--

Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх

4.4.1.	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	<p>Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх</p> <p>Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн</p>	<p>Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.</p>	<p>Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.</p> <p>- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв</p>	<p>Нийгмийн даатгалын шинэ систем Sicos-д ажил олгогчийн болон даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэт оруулан бүртгэж, ажил олгогчийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хамт файлаар хавсарган мэдээллийн санд бүртгэж байна. 2024 оны 12 сарын 09-ний байдлаар нийт 146 аж ахуй нэгжийн 253 албан журмын даатгуулагч шинээр хамруулж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.</p>	100%
--------	--	---	---	---	---	------

			<p>мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх</p>		<p>хүлээн авсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. 	
			<p>Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх</p>		<p>Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна.</p>	
4.4.3.	<p>Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах</p>		<p>Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах</p>		<p>Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.</p>	<p>2024 онд Нийгмийн даатгалын үйлчлэл шинэ программ нэвтрүүлж систем шинэчлэл хийгдсэн. Үүнтэй холбоотой мэдээллийн технологи хэрэглэгч мэргэжилтнүүдэд МТТ-өөс эрхийн туслах admin эрхийг олгосны дагуу болон сумын 41 байцаагчид программ нэвтрэх эрхийн тохиргоог үүргийнх нь хүрээнд тохируулж, бүрийн программ нэвтрэх нэр, нууц ал баны и-мэйлээр нь баталгаажуулсан. Байцаагч нар програм хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан газар албан хаагчдыг арга зүйгээр ажилласан.</p>

						IT Zone, МТТ-өөс зохион байгуулсан Sicos программын зааварчилгаатай холбоотой системийн ерөнхий заавар 1, тэтгэврийн даатгалын талаар 3, тэтгэмжийн даатгалын талаар 4, ҮОМШӨ-ний Сэргээн засах сувиллын зардлын талаар 2, сайн дурын даатгалын талаар 2, албан журмын даатгалын талаар 3, санхүү бүртгэлийн чиглэлээр 7, ажил олгогчийн тайлангийн системийн талаар 3, даатгуулагчид зориулсан вэб системийн талаар 1, зөрчлийн системийн талаар 2 нийт 28 заавар чиглэлийг хэрэгжүүлж, албан хаагчдад тухай бүр мэдээлж ажилласан.	
--	--	--	--	--	--	--	--

ЗУРГАА. ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

6.1.1	Төрийн албаны болон нийгмийн даатгалын ажилтны ёс зүй, сахилга батыг чанд сахиж, ажлын хариуцлага, цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа сайнаачлагатай, үр дүнтэй гүйцэтгэх, ажлын байрны стандарт, дэг журмыг мөрдөн ажиллах	Төрийн албаны тухай хууль болон нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийн дагуу ажиллах	Төрийн албаны тухай хууль болон нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийн дагуу ажиллах	Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийг чанд сахин зөрчилгүй ажиллаж байна.	100%
6.1.3	Албан үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн болон харилцааны доголдол гаргасан, хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор ажил үүргээ	Төрийн албан тухай хууль болон нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн дүрэм журмыг баримтлан ажиллах	Төрийн албан тухай хууль болон нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн дүрэм журмыг баримтлан ажиллах	Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хувийн болон бусдын ашиг сонирхолын төлөө ашигласан зөрчил гаргалгүй ажиллаж байна. Албан үүргээ гүйцэтгэхдээ иргэд даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд	100%

	зохих ёсоор биелүүлээгүй, шан харамж авсан, хийх ёсгүй үйлдэл гаргасан байцаагч, ажилтнуудтайгаа хуулийн дагуу хатуу хариуцлага тооцож ажиллах			шийдвэрлэж, харилцаа хандлагаараа эс үйлдэхүй гарган, шалтгаангүй хойшлуулж, шан харамж хүсэж, албан үүргээ шуурхай гүйцэтгэхээс зайлсхийсэн үйлдлийг гаргахгүй ажил үүргээ гүйцэтгэдэг.	
6.1.5	Ажлын цагаар ажлын тусгай хувцсыг баталсан стандартын шаардалгын дагуу иж бүрэн өмсөж хэвших, энгийн хувцастай хослуулж хэрэглэхгүй байх	Баталсан ажлын хувцсыг стандартын дагуу өмсөх	Ажлын хувцсыг тогтмол өмсөх, шинээр орсон байцаагч ажилтнууд дүрэмт хувцастай болсон байна.	Ажлын цагаар албаны дүрэмт хувцасыг тогтмол өмсөж хэвшсэн.	100%
6.1.7	Хамт олонч, нийтэч, тусч, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэхэд анхаарч, ёс зүйн сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх зорилтыг дэвшүүлж ажиллах	Байцаагч ажилтнуудын ажлын байранд хамт олонч, нийтэч уур амьсгалыг бий болгох, мэдлэг ур чадвар, туршлагаасаа залуу шинэ байцаагч ажилтнуудад хуваалцах	Ахмад үеийн ажилтнуудаас туршлага судалж, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх, ахмадын сангийн мөнгөн хөрөнгийг өсгөх, нийт ажилтнуудын идэвхи оролцоог нэмэгдүүлж, бүх нийтийн үйл ажиллагаанд тогтмол хамруулсан байна.	Нийгмийн даатгалын ахмад үеийн ажилтнуудаас туршлага судлах, дотооддоо бие биеэсээ суралцаж, хамт олны найрсаг уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч хувь хүний ёс зүй, эерэг хандлага сэдэвт сургалтад цахимаар хамрагдан өөрийгөө хөгжүүлэн ажиллаж байна.	100%

ДОЛОО. 2024 ОНЫ "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ"
НЭРЛЭСЭН ЖИЛИЙН ХҮРЭЭНД:

7.1.1	“Нийгмийн даатгалын Хамралтыг нэмэгдүүлэх” нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулсан ажил	Нэрлэсэн жилийн хүрээнд газраас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцох	Нэрлэсэн жилийн хүрээнд газраас зохион байгуулсан ажлын хүрээнд идэвхтэй оролцож ажиллана.	<p>Явуулын үйлчилгээ, өдөрлөг арга хэмжээг зах, ХҮТөв, ЕБСургуулийн төгсөх ангийн сурагчдад, 24 сумын 129 багийн 8430 малчид, даатгуулагчдад 92 удаагийн иргэд нийтийн хурлаар дамжуулан НД-ын хууль тогтоомж, үйлчилгээг хүргэж ажиллалаа. Үүнд: 2024.04.23-нд “Хөвсгөл Органик” бизнес эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн, 2024.05.01-нд “Хуульчийн Про-Боно өдөр-2024” нээлттэй өдөрлөг, 2024.05.09-нд “Төрийн байгууллагын бүтээлч үйл ажиллагаа” зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаж НДГазраас тус арга хэмжээнд оролцож 1550 иргэнд НД-ын үйлчилгээг хүргэж ажилласан байна.</p> <table border="1" data-bbox="1361 579 1888 778"> <thead> <tr> <th rowspan="2"></th> <th colspan="3">Сургалт</th> <th colspan="2">А/хэмжээ</th> </tr> <tr> <th>Сурга лт тоо</th> <th>АО тоо</th> <th>Даатгу у-лагч тоо</th> <th>А/Хэм тоо</th> <th>Иргэд тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хэлтэс</td> <td>11</td> <td></td> <td>392</td> <td>3</td> <td>1550</td> </tr> <tr> <td>Сум</td> <td>108</td> <td>305</td> <td>2713</td> <td>92</td> <td>6680</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>119</td> <td>475</td> <td>1705</td> <td>95</td> <td>8230</td> </tr> </tbody> </table>		Сургалт			А/хэмжээ		Сурга лт тоо	АО тоо	Даатгу у-лагч тоо	А/Хэм тоо	Иргэд тоо	Хэлтэс	11		392	3	1550	Сум	108	305	2713	92	6680	Нийт	119	475	1705	95	8230	Хагас жилийн байдлаар 100%
	Сургалт			А/хэмжээ																														
	Сурга лт тоо	АО тоо	Даатгу у-лагч тоо	А/Хэм тоо	Иргэд тоо																													
Хэлтэс	11		392	3	1550																													
Сум	108	305	2713	92	6680																													
Нийт	119	475	1705	95	8230																													
7.1.2	“Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих” аймгийн нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулсан ажил	Нэрлэсэн жилийн хүрээнд аймгаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцох	Нэрлэсэн жилийн хүрээнд аймгаас зохион байгуулсан ажлын хүрээнд идэвхтэй оролцож ажиллана.	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан бүтэн өнчин хүүхдүүдэд туслах хандивын арга хэмжээнд оролцсон.</p> <p>Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн Мандахцэцэг багштай 12-р ангийн сурагчдад Аэробик гимнастикаар Олон улсын тэмцээнд явахад дэмжлэг үзүүлж хандив өгсөн.</p>	100%																													
НАЙМ. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:																																		
8.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дэг журмыг сахиж авлига, ашиг сонирхолын зөрчилд автахгүй ажиллах	Хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажилласан байна.	Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд сахин ажиллаж, авлига ашиг сонирхолын зөрчил гаргалгүй ажилласан байна.	Иргэд даатгуулагчдад хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд хүргэхэд нэн шаардлагатай хууль тогтоомж, дүрэм журам, нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн дүрэм зэргийг уншиж судлан, төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахин зөрчилгүй ажиллаж байна.	100%																													

8.2	Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхолын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх	Ажлын гүйцэтгэл сайжирсан байна.	Төрийн албаны болон хувь хүнийг нууцын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана.	Төрийн албаны болон хувь хүний нууцын тухай хуулийг хэрэгжүүлж, байгууллагын нууцын баталгааг ханган хувь хүний тэтгэвэр, тэтгэмжийн болон бусад нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй чанд хадгалан ажиллаж байна.	100%
8.3	Төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх	Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхдээ хурдан шуурхай чирэгдэлгүй, ялгаварлалгүй хүргэсэн байна.	Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэхийг зорьж, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй тэгш үйлчилж байна.	100%
8.4	Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх	Хуулиар зөвшөөрөгдөөгүй давхар ажил эрхлэхгүй байх	Хуулиар зөвшөөрөгдөөгүй давхар ажил эрхлээгүй байна.	Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрөгдөөгүй давхар ажил хөдөлмөр эрхлээгүй болно.	100%

8.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам, заавар, стандартыг мөрдөж ажиллах	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг үйл ажиллагаандаа өдөр тутам мөрдөн ажиллаж, албан бичиг боловсруулах, тайлан мэдээ гаргах, архивт баримтаа шилжүүлэхэд архив, албан хэрэг хөтлөлтийн журам, зааврын дагуу үйлдэн ажиллаж байна. 2024 оны 1 дүгээр улиралдаа багтаан архивт 7 хадгаламжийн нэгж бүртгэлээр шилжүүлэн өгсөн.	100%
8.6.	Харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах асуудал шийдэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндсэлэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвөлгөөгөөр хангах	Удирдлага үнэн зөв мэдээлэлээр хангагдаж зөв шийдвэр гаргана.	Удирдлага үнэн зөв мэдээлэлээр хангагдаж ажилласан байна.	Харьяа дээд шатны байгууллага болон газрын удирдлагыг тухай бүр холбогдох бодит мэдээллээр ханган ажиллаж байна.	100%
ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ					
1.1.	2025 оноос төрийн албан бичгийг Монгол бичгээр хөтлөх үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлэх	Мэдлэгийн түвшин 60 хувьд хүрсэн байна.	Мэдлэгийн түвшин 60 хувьд хүрсэн байна.	Монгол бичгээр бичих болон унших чадвар сайн. Төрийн албан хэрэг хөтлөлтийг 2025 оноос Монгол бичгээр хөтлөн явуулах болсонтой холбогдуулан албан бичгийг монгол бичгээр боловсруулах дадлага хийж, албан хаагчдын компьютерт Монгол бичгийн фонт суулгасан.	100%
1.2.	Мэдээллийн шинэ системд нэвтрүүлэх ажлын хүрээнд хийгдэх	Программуудыг бүрэн эзэмшсэн байна.	Программуудыг бүрэн эзэмшсэн	2024 онд Нийгмийн даатгалын үйлчилгээнд мэдээллийн шинэ систем (Core), даатгалын үйлчилгээ болон ажил олгогчийн шинэ цахим систем portal.ndaatgal.mn – ийг	100%

	шинэ программуудын сургалтад хамрагдаж мэдээллийн системд ажиллах чадвараа дээшлүүлэх		байна.	нэвтрүүлж, иргэд даатгуулагч, ажил олгогч нарт шинэ цахим үйлчилгээг сурталчлан таниулах, хэрхэн ашиглах талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, байцаагч нарт Sicos программын хөгжүүлэлтийн мэдээллийг тухай бүр хүргэх, системд гарч буй алдаа зөрчлийг дээд газарт мэдээлэх зэргээр системийн шинэчлэлийг бүрэн хүрээнд судлан ажиллалаа.	
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
2.1.	Нийгмийн даатгалын тухай хууль, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, түүнийг дагаж гарсан дүрэм, журмыг уншиж судалж бүрэн хэрэгжүүлэх	Хууль, дүрэм, журмыг бүрэн судалсан байна.	Хууль тогтоомж, дүрэм, журмыг уншиж судлан иргэд даатгуулагч, ажил олгогчдыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 469-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм", 2-р хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм", НДЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан "Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
2.2.	Төрийн албаны тухай хууль, түүнийг дагаж гарсан журмууд, Шинээр мөрдөгдөж эхэлж буй хөдөлмөрийн тухай хуулийг судлах	Хууль, дүрэм, журмыг бүрэн судалсан байна.	Уншиж судлах	Хууль, эрх зүйн мэдээллийн нэгдсэн портал legalinfo.mn сайтаас болон Монгол улсын төрийн албаны зөвлөлийн вебсайтаас шинээр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн тухай хууль, төрийн албаны тухай хууль болон шинээр батлагдсан хууль тогтоомж, дагаж мөрдөх дүрэм журам, мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь авч уншиж судлан, иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

...../Б.БЯМБАДУЛАМ/
(Нэр, гарын үсэг)

2024.12.10
(Огноо)